



**БНМАУ  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

1991 оны 10 сарын 16

№ 207

Улаанбаатар хот

Зарим цэг салбарт нэр өгөх тухай

Нийслэлийн нийтийн хоолны зарим цэг салбараас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. МАХН-ын Төв Хороо, Улаанбаатар хотын МАХН-ын хорооны шинэ байранд нээгдэх зоогийн газрыг "Сэлэнгэ", Сүхбаатарын районы худалдаа, хоолны компанийн харъяа хуучин "Бамбарууш" зоогийн газрыг "Мандал" нэртэйгээр ажиллуулсугай.

2. Энэ тогтоол гарах болсонтой холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1984 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн "Хүүхдийн хоолны гуанз нээж ажиллуулах тухай" 105 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

ХӨРӨГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

*[Handwritten signature]*

Л.ЭНЭБИШ

*[Handwritten signature]*

Ц.БОЛДСАЙХАН